



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/27


Шивээговь сум

Сумын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дэд хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 42 дугаар зүйлийн 42.1.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 95 дугаар тогтоол, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 11 дүгээр тогтоол “Сумын 2020 оны төсөв батлах тухай”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дэд хөтөлбөрийг 2020 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсүгэй.
2. Сумын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дэд хөтөлбөрийг 2020 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. Төлөвлөгөөний зардалд зарцуулагдах 10000000 /арван сая/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч /О.Дөлгөөн/-д зөвшөөрсүгэй.
4. Хөтөлбөрийг иргэдэд нээлттэй зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн иж бүрдлийг ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 0095

Сумын Засаг даргын 2020 оны 02-р сарын 18-ны  
 өдрийн 1417 дугаар захирамжийн хавсралт



СУМЫН АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
 АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Санхүүжилт	Хариуцах эзэн	
1.	НЭГ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.	Геронтологийн үндэсний төвтэй хамтран настны эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг зохион байгуулах	Жилдээ	Ахмад настны хамрагдалт	– 30-аас доошгүй хувь	200,000	Эрүүл мэндийн төв	
2.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дотрын эмчийн үзлэг зохион байгуулах	Жилдээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалт	– 30-аас доошгүй хувь	100,000	Эрүүл мэндийн төв	
3.		Ахмад настануудын дунд дасгал хөдөлгөөний тэмцээн зохион байгуулах	5-р сард	Нийт ахмадын 30-аас доошгүй хувийг хамруулах	Нийгмийн идэвхийг сайжруулж, оролцоог нэмэгдүүлсэн байна.	810,000	ЗДТГ Эрүүл мэндийн төв Ахмадын хороо	
4.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд аялал зохион байгуулах	9-р сард	Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 30%-аас доошгүй хамруулах	Нийгмийн идэвхийг сайжруулж, оролцоог нэмэгдүүлсэн байна.	465,000	ЗДТГ	
5.		ХОЁР. Ахмад настан,	Ахмадын хорооны байрны тохижилтыг хийх	2-р улиралд	Шинэчилж солих цонх, хаалганы тоо	5 цонх, 2 хаалга	2,300,000	ЗДТГ
6.		хөгжлийн	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд монгол	4-р сард	Хөгжлийн бэрхшээлтэй	- 30%-аас доошгүй	500,000	ЗДТГ Соёлын

	бэрхшээлтэй иргэдийг хамт олны дунд бусдын адил хөгжих, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх боломжийг бүрдүүлэх	наадгайн тэмцээн зохион байгуулах		иргэдийн хамрагдалт			төв
7.		Соёлын биет болон биет бус өв өвлөн уламжлагчдын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулах	3-р сард	Өв тээгчдийн хамрагдалт	- 60-аас доошгүй хувь	2,500,000	ЗДТГ Соёлын төв
8.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн тоглолт зохион байгуулах	Жилдээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалт	- 30%-аас доошгүй	300,000	ЗДТГ Соёлын төв
9.		Ахмадын баярыг тохиолдуулан спортын тэмцээн зохион байгуулах	9-р сард	Нийт ахмадын 30-аас доошгүй хувийг хамруулах	Нийгмийн идэвхийг сайжруулж, оролцоог нэмэгдүүлсэн байна.	549,000	ЗДТГ
10.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах	10-р сард	Зорилтот 2 арга хэмжээг зохион байгуулсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.	926,000	ЗДТГ Соёлын төв
11.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	10-р сард	Арга хэмжээний тоо	- 1 - Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хамруулсан байна.	500,000	ЗДТГ ЕБС
12.		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургалтын ном, хичээлийн хэрэгсэл олгох	Жилдээ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт	- 100%	500,000	ЗДТГ ЕБС
13.		Сум орон нутгаа төлөөлөн хурал, тэмцээн уралдаанд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулах	Жилдээ	Хурал, тэмцээн, уралдааны тоо – 3-аас доошгүй	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн идэвхийг сайжруулсан байна.	350,000	ЗДТГ

14.		Багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд сургах сургалтанд хамруулах	Жилдээ	Сургалтын тоо - 1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэдлэгтэй болсон байна.	-	ЕБС
		<b>Нийт дүн</b>				<b>10,000,000</b>	

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: *Б.Баасанбат*

Б.БААСАНБАТ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН:

*З.Баасандалай*

З.БААСАНДАЛАЙ